

**“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 05 өдөр

№ 08/05

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
даргыг томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйл, “Монос Хүнс” ХК-ийн дүрмийн 7.4 дүгээр заалт, 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Хүрэлбаатар овогтой Анандыг томилсугай.
2. Ажил үүрэг гүйцэтгэхтэй холбоотой мөрдвөл зохих хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон баримтлаж, хуулийн хүрээнд ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Х.Анандад үүрэг болгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Х.Анандыг зохих журмын дагуу цалинжуулахыг “Монос хүнс” ХК-ийн Ерөнхий нягтлан бодогч /Ц.Дэлгэрмаа/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

Х.АНАНД



**“МОНОС ХҮНС” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 05 өдөр

№ 09/05

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх
хороодын дарга, гишүүдийг томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, “Монос Хүнс” ХК-ийн дүрмийн 7.15, 7.16, 7.17, 7.18 дугаар заалт, 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монос хүнс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгосонтой холбоотой ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
 - 1.1. Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн О.Лхагвасүрэнг, гишүүдээр ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Гантулга, ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Цэцэгбадам нарыг,
 - 1.2. Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Гантулга, гишүүдээр ТУЗ-ийн хараат бус гишүүн Ш.Алтанбагана, ТУЗ-ийн ердийн гишүүн Х.Солонго нарыг,
 - 1.3. Стратеги, бизнес хөгжлийн хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Ш.Алтанбагана, гишүүдээр ТУЗ-ийн хараат бус гишүүн О.Лхагвасүрэн, ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Гантулга, ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Цэцэгбадам, ТУЗ-ийн ердийн гишүүн Ч.Баттогтох нарыг,
2. Ажил үүрэг гүйцэтгэхтэй холбоотой мөрдвөл зохих хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон баримтгаж, хуулийн хүрээнд ажиллахыг шинээр томилогдсон хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын дарга, гишүүдийг зохих журмын дагуу цалинжуулахыг “Монос хүнс” ХК-ийн Ерөнхий нягтлан бодогч /Ц.Дэлгэрмаа/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Х.АНАНД